



Co-funded by
the European Union



"БУЦАХ ШИЛЖИЛТ ХӨДӨЛГӨӨН БА ЭРГЭН СУУРЬШИХЫН АСУУДЛУУД" СЭДЭВТ СУДАЛГААНЫ УРАЛДААН

Улаанбаатар хот, Монгол улс, 2023 оны 11 дүгээр сарын 9

СУДАЛГААНЫ ЭМХЭТГЭЛ



Олон Улсын Шилжилт Хөдөлгөөний Байгууллага
2023 он

Өмнөх үг

Олон Улсын Шилжилт Хөдөлгөөний Байгууллага нь 2023 онд Бельги улсын тусгай сангийн санхүүжилтээр хэрэгжүүлж буй үйл ажиллагааны хүрээнд Монгол Улсын Их Сургуулийн Олон Улсын Харилцаа, Нийтийн Удирдлагын Сургуультай хамтран “Буцах шилжилт хөдөлгөөн ба эргэн суурьшихын асуудлууд” сэдэвт судалгааны уралдааныг зохион байгууллаа. Арга хэмжээний гол зорилго нь Монгол Улсад буцаж ирэх шилжилт хөдөлгөөн, эргэн суурьшихын чиглэлээрх судалгаа, эрдэм шинжилгээний ажлыг дэмжих, сурталчлах явдал байв. Судалгааны уралдааныг 2023 оны 5-р сард зарлаж, 2023 оны 10-р сарыг дуустал материал хүлээн авсан бөгөөд шаардлага хангасан бүтээлүүдийг танилцуулж, хэлэлцэх эрдэм шинжилгээний хурлыг 2023 оны 11-р сарын 9-нд зохион байгуулав.

Ирүүлсэн судалгааны ажлуудаас шаардлага хангасан 4 судалгаа 2023 оны 11-р сарын 9-нд МУИС-ын ОУХНУС-д зохион байгуулагдсан эрдэм шинжилгээний хуралд илтгэл хэлбэрээр танилцуулагдав. Хурлын үеэр оюутны төрөлд хоёр илтгэл, судлаачийн төрөлд хоёр илтгэл тавигдсан бөгөөд оюутан, судлаач нар хийсэн судалгааны ажлынхаа талаар танилцуулж, шүүгчид асуулт асууж, цаашид судалгаагаа өргөжүүлэх, хэвлүүлэх талаар санал, зөвлөмж өгсөн юм. Илтгэлүүдийн дараагаар шүүгчид судалгааны ажлуудад өгсөн оноогоо нэгтгэн дараах үр дүнг танилцуулав:

Судлаачийн төрөлд тэргүүн байр:..... 4

У.Индра /Монгол Улсын Их Сургуулийн Олон Улсын Харилцаа, Нийтийн Удирдлагын Сургуулийн судлаач/ - “Олон улсын шилжилт хөдөлгөөний асуудал монгол улсын жишээ”

Оюутны төрөлд тэргүүн байр: 17

Г.Мягмарцэрэн, О.Цэнгүүн /Монгол Улсын Их Сургуулийн Шинжлэх Ухааны Сургуулийн Нийгмийн Ухааны Салбарын Эдийн засгийн тэнхмийн оюутнууд/ - “Монгол улсад буцан ирэх шилжилт хөдөлгөөний өнөөгийн хандлага, төлөв байдал”

Судлаачийн төрөлд дэд байр:..... 23

Я.Мичидмаа /Олон улсын харилцааны бакалавр, хувь судлаач/ - “Цар тахлын үед монгол улсад тулгамдсан гадаадаас буцах шилжилт хөдөлгөөн ба эргэн суурьшихын асуудлууд болон цар тахлын дараах боломж”

Оюутны төрөлд дэд байр: 25

Б.Алтансүвдмаа /Монгол Улсын Их Сургуулийн Олон Улсын Харилцаа, Нийтийн Удирдлагын Сургуулийн магистрант/ - “Гадаадаас буцах шилжилт хөдөлгөөн ба эргэн суурьшилтын асуудлууд”

Энэхүү эмхэтгэлд тэргүүн байранд шалгарсан судалгаанууд бүрэн эхээр, хоёрдугаар байранд шалгарсан судалгаануудын хураангуй багтсан болно.

Судлаачийн төрөлд тэргүүн байранд шалгарсан судалгаа:**ОЛОН УЛСЫН ШИЛЖИЛТ ХӨДӨЛГӨӨНИЙ АСУУДАЛ МОНГОЛ УЛСЫН ЖИШЭЭ**

Зохиогч: Ө.Индра / Монгол Улсын Их Сургууль, Олон Улсын Харилцаа, Нийтийн Удирдлагын Сургууль - Судлаач/

Удирдсан багш: Д. Оюунсүрэн / Монгол Улсын Их Сургууль, Олон Улсын Харилцаа, Нийтийн Удирдлагын Сургууль - Ахлах багш/

Хураангуй: “Гадаадаас буцах шилжилт хөдөлгөөн ба эргэн суурьшихын асуудлууд” сэдэвт судалгааны уралдаанд “Олон улсын шилжилт хөдөлгөөний асуудал Монгол Улсын жишээн дээр” судалгаагаараа оролцож байна. Энэхүү судалгаагаар олон улсын шилжилт хөдөлгөөний талаар судлах, энэ сэдвийн ач холбогдлыг гаргаж ирэх, цаашлаад хилийн чанад дахь Монголчуудад тулгамдаж буй асуудлыг олж илрүүлэх зорилго тавьсан бөгөөд эл зорилгынхоо хүрээнд Монголчууд ямар шалтгааны улмаас шилжилт хөдөлгөөн хийх болсон, гадаадад тэдэнд учирч байгаа тулгамдсан асуудлууд юу болох, буцах шилжилт хөдөлгөөн хийхэд ямар саад бэрхшээлүүд үүсдэг, Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлдэг холбогдох бодлого хөтөлбөрүүдэд тусгах шаардлагатай асуудлууд юу болох талаар тус тус судлан тодруулсан.

Мөн Хилийн чанад дахь Монголчуудыг хариуцан Монголын ЗГ-ын зүгээс Консулын газраас оновчтой үйлчилгээ үзүүлэх, сонгуульд идэвхтэй оролцуулах, Монгол Улс болон Хилийн чанад дахь Монголчуудын хооронд харилцан ашигтай бодлого хөтөлбөр, бүлэг бүрийн онцлог, сонирхлын дагуу хамрагдах боломжтой хөтөлбөр, төслүүдийг хэрэгжүүлэх, мөн Монгол руу буцааж ирүүлэхэд болон гадаадад амьдарч байх үед нь дэмжих гэсэн хосолсон бодлого хэрэгжүүлэх шаардлагатай гэсэн саналыг судалгаагаараа дэвшүүлэн судалгааны эцэст нь Хилийн чанад дахь Монголчуудад хангалттай анхаарал хандуулдаггүй нь өөрөө Монгол Улс дахь ОУШХ-ний тулгамдсан асуудал юм байна гэж дүгнэсэн.

1. УДИРТГАЛ

Судалгааны үндэслэл, шаардлага

Аливаа нэг газраас нөгөө газар луу шилжин суурьших, нүүх хэмээх үзэгдэл нь хүн төрөлхтний хувьд анх хүн үүсэж бий болсон цагаас хойш оршин байсан ба энэ утгаараа хүн төрөлхтөн ба шилжин суурьшилт гэсэн хоёр ойлголт хоорондоо салшгүй холбоотой юм.

Олон улсын шилжилт хөдөлгөөн нь дотроо хэд хэдэн эргэлтийн цэг бүхий баялаг түүхтэй бөгөөд Дундад зууны нийгмийн задрал, түүнийг дагасан Сэргэн мандалт, худалдааны хувьсгал, колоничлол, хөдөө аж ахуйн хувьсгал, аж үйлдвэрийн хувьсгал, чөлөөт зах зээлийн нийгэм, орчин үеийн техник технологийн дэвшил зэрэг өөрчлөлтүүд нь олон улсын шилжилт хөдөлгөөнийг өсөн нэмэгдэхэд нөлөөлсөн томоохон хүчин зүйлс юм.

Шилжилт хөдөлгөөн нь зөвхөн эдийн засгийн хүчин зүйлээс гадна нийгэм, улс төр, соёл, байгаль орчин, эрүүл мэнд, боловсрол гэх зэрэг олон хүчин зүйлээс үүдэлтэй дэлхий нийтийг хамарсан үзэгдэл бөгөөд салбар бүрийн эрдэмтэн, судлаачид шилжилт хөдөлгөөнийг янз бүрийн зорилгоор судалсаар¹ ирсэн. Шилжилт хөдөлгөөн дэлхий дээрх бараг бүх улс оронд ямар нэгэн байдлаар нөлөөлсөөр ирсэн, цаашид ч энэ хэвээр байх бөгөөд улс орнуудын хөгжил, ядуурал, хүний эрх зэрэг дэлхийд тулгамдаж буй бусад чухал асуудлуудыг хөнддөг учир энэ үзэгдлийг улам дэлгэрүүлэн судлах шаардлага үүсэж байна.

Сэдвийг сонгосон шалтгаан

2021 онд НҮБ-ын Шилжилт Хөдөлгөөний Байгууллага Бритиш Колумбийн Их Сургууль (University of British Columbia)-тай хамтран 2021-2022 оны хооронд явуулж байгаа Global Policy Project (GP2)-ын төслийн хүрээнд тус сургуулийн магистрын оюутнуудын хамтран хэрэгжүүлж буй “Диаспорагийн оролцооны стратеги – Хойд Америк дахь Монголчуудын тухай тайлан” (Diaspora Engagement Strategy – Report on Mongolian Diaspora in North America) судалгаанд ОУХНУС-ийг төлөөлөн оролцож байгаа бакалаврын хоёр оюутны нэгээр миний бие шалгаран Монгол диаспорагийн талаар судлах явцад хилийн чанад дахь Монголчууд ба тэдний өнөөгийн нөхцөл байдал, тулгамдсан асуудлын талаар судалгааны хэрэгцээ шаардлага байгааг олж харсан учир энэхүү сэдвийг сонгох болсон.

Судалгааны ажлын зорилго, зорилт

Уг судалгааны ажлаар олон улсын шилжилт хөдөлгөөний талаар судлах, энэ сэдвийн ач холбогдлыг гаргаж ирэх, цаашлаад хилийн чанад дахь Монголчуудад тулгамдаж буй асуудлыг олж илрүүлэх зорилго тавьсан. Зорилгын хүрээнд - Олон улсын шилжилт хөдөлгөөний өнөөгийн байдал, зохицуулалтыг таньж мэдэх, - Хилийн чанад дахь Монголчуудад тулгамддаг асуудлуудыг илрүүлж тогтооход чиглэх зорилтуудыг дэвшүүлсэн.

Судалгааны асуулт

Хилийн чанад дахь Монголчуудад тулгамддаг асуудлуудыг судлах явцад Монгол Улсын Засгийн газар хилийн чанад дахь иргэддээ анхаарал хандуулдаг уу? гэсэн асуултыг тавихад хүргэсэн.

Судалгааны ажлын шинэлэг тал

Монгол Улсын дотоод шилжилт хөдөлгөөнд төвлөрсөн судалгааны ажил, тайлан, баримт бичгүүд харьцангуй олдоцтой байдаг ч гадаадын улс орнуудад ажиллаж, амьдарч байгаа Монголчууд

¹ Kyaing Kyaing Thet. “Pull and Push Factors of Migration: A Case Study in the Urban Area of Monywa Township, Myanmar”, (2012): p.1

мөн тэдэнд тулгардаг асуудал, бэрхшээлийн талаарх судалгаа хомс байдаг. Энэхүү судалгаагаар түүврийн аргаар сонгосон 250 орчим иргэдийн санал асуулга, ярилцлага болон салбарын мэргэжилтнүүдтэй ярилцсан ярилцлага, дүгнэлт, санал зэрэг мэдээллийг цуглуулан, нэгтгэн, боловсруулснаараа шинэлэг болсон.

Судалгааны арга зүй

Энэхүү судалгааны ажлыг холимог аргачлалаар хийсэн бөгөөд эхний үе шатанд олон улсын шилжилт хөдөлгөөний хэв маяг, өнөөгийн байдал, зохицуулалтын талаарх мэдээлэл цуглуулалтыг хоёрдогч эх сурвалжаас баримт бичгийн судалгааны арга ашиглан гүйцэтгэсэн ба дараагийн үе шатанд хилийн чанад дахь Монголчуудаас түүврийн аргаар асуулга авч, дараа нь мэргэжилтнүүдтэй ганцаарчилсан ярилцлага хийх замаар илүү нарийвчилсан мэдээлэлтэй болохыг зорьсон.



Зураг 1: Судалгааны арга зүй

Ийнхүү холимог аргачлалаар судалгааг явуулснаар нэг талыг баримталсан үр дүн гарахаас зайлсхийж эл асуудлаарх жирийн иргэдийн байр суурь болон мэргэжилтнүүдийн (НҮБ-ын Шилжилт Хөдөлгөөний Байгууллагын мэргэжилтнүүд болох Хөтөлбөрийн удирдагч Виктор Лутенко (Victor Lutenco), хөтөлбөрийн ажилтан М.Бямбасүрэн болон төслийн ажилтан С.Мөнхчулуун, түүнчлэн ОУШХБ-ын Дэлхийн Бодлогын Төслийн (Global Policy Project) ахлагч, Бритиш Колумбиагийн Их Сургуулийн профессор, доктор Жулиан Диеркес (Julian Dierkes) үзэл бодлыг тусгаж, тулгамдаж буй асуудлыг олон талаас нь үнэлэн дүгнэхийг эрмэлзсэн.

Сэдвийн судлагдсан байдал

Гадаад хэл дээр олон улсын шилжилт хөдөлгөөн болон тэдгээрт тулгамдсан асуудлын талаарх судалгаа нэлээд хийгддэг, тухайлбал НҮБ-ын Шилжилт Хөдөлгөөний Байгууллагаас жил бүр гаргадаг Шилжилт хөдөлгөөний тайлан (World migration report), Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагаас дээрх сэдвээр эрхлэн гаргасан судалгааны нийтлэлүүд, тухайлбал "Олон улсын шилжилт хөдөлгөөн: Даяаршил" 2009, "Олон улсын шилжилт хөдөлгөөний үндсэн чиг хандлага" 2003, цагаачлал ба шилжилт хөдөлгөөний нэрт судлаач Стивен Кэстлс (Stephen Castles)-ын "21-р зууны эхэн үеийн олон улсын шилжилт хөдөлгөөн: Дэлхийн чиг хандлага ба асуудлууд" (International migration at the beginning of the twenty-first century: Global trends and issues) 2002, мөн диаспора болон цагаачдын улс төрийн оролцооны сэдвээр голдуу бүтээл гаргадаг Лондонгийн Эдийн засаг, улс төрийн их сургуулийн Олон улсын харилцааны тэнхимийн судлаач Эва Остергаард-Нильсен (Eva Шstergaard-Nielsen)-ий "Олон улсын шилжилт хөдөлгөөн ба Илгээгч улсууд: Гол асуудлууд ба Үндсэн санаа" (International Migration and Sending Countries: Key Issues and Themes) 2003 зэргийг дурдаж болно.

Монгол Улсын шилжилт хөдөлгөөний талаар хийгдсэн судалгаа маш цөөн, тэр дундаа Монгол Улсын олон улсад хийх шилжилт хөдөлгөөний талаар судалгаа ихээхэн хязгаарлагдмал байдаг. Гэхдээ АНУ-ын Монтерей дахь Мидлбери олон улс судлалын хүрээлэнгийн профессор Цунео Акаха /Tsuneo Akaha/-ын “Монгол дахь олон улсын шилжилт хөдөлгөөн, хүний аюулгүй байдал ба түүний хөгжил” (International Migration and Human Security and Development in Mongolia) хэмээх судалгаа, МУИС-ийн ОУХНУС-ийн ахлах багш Д.Оюунсүрэнгийн 2011 “Brain drain or Brain gain: The case of Mongolia” судалгаа, НҮБ-ын ОУШХБ Монгол Улс дахь дотоод шилжилт хөдөлгөөний судалгааг түлхүү хийсээр ирсэн бөгөөд 2020 оноос эхлэн гадаад шилжилт хөдөлгөөний судалгааны ажлууд эхний шатанд явж байгаагийн нэг жишээ бол НҮБ-ын ОУШХБ-ын Монгол дахь салбар нь Хилийн чанад дахь Монголчуудын зөвлөлтэй хамтран “Хилийн чанадад үйл ажиллагаа явуулдаг Монголчуудын холбоо, байгууллага, үндсэн шинж чанар, хөгжлийн ерөнхий хэрэгцээний талаар” 2021 оны 7-р сард хийсэн судалгаа, мөн МУИС-ийн Улс төр судлалын тэнхимийн Дэд Профессор Д.Бумдарийн “Монгол ба Олон улсын шилжилт хөдөлгөөнд КОВИД-19-ийн нөлөө тойм судалгаа” (2020) зэрэг цөөн тооны судалгаануудыг зайлшгүй дурдах ёстой. Түүнчлэн Хилийн чанадад буй монгол иргэдэд хандсан нэгдмэл цогц бодлого хэрэгжүүлэх, иргэдэд тулгарч буй асуудлын шийдлийг тодорхойлох, хилийн чанадад буй Монгол Улсын иргэдээс эх орныхоо хөгжил дэвшилд хувь нэмрээ оруулах нөхцөлийг бүрдүүлэх зорилго бүхий Монгол Улсын Засгийн газраас 2016 онд баталсан “Дэлхийн Монголчууд” хөтөлбөрийг² дурдвал зохино. Тус хөтөлбөрт олон улсын томъёолж буй “brain circulation” буюу иргэд мэдлэг, боловсрол, үйл ажиллагаа, харилцаа холбоогоор эх орныхоо бүтээн байгуулалтад хувь нэмрээ оруулахыг дэмжих, иргэний бүртгэлийг сайжруулах, иргэдийн нийгэмлэг холбоодтой хамтран ажиллах зорилтуудыг тусгасан байна. Дээрх хөтөлбөр хэрэгжихээс өмнө хилийн чанад дахь монголчуудаа эргүүлэн татахын тулд Үндэсний хөгжил шинэтгэлийн хорооноос “Зөгийн үүр” хөтөлбөрийг 2010 онд боловсруулж байв³. Тус хөтөлбөрийн хэрэгжилтийн хувьд хэдийгээр сайн эхлэл тавигдсан ч одоо тус зөвлөл нь ямар үйл ажиллагаа явуулж байгаа нь тодорхойгүй байна⁴. Доктор О.Нямдаваа нь “Дэлхийн Монголчууд” хэмээх анхны номыг дэлхийн өнцөг бүрийн монголчуудыг холбох зорилгоор англи хэлээр хэвлүүлсэн нь мөн энэ салбарын судалгаанд өөрийн хувь нэмрийг оруулсан байдаг.

Монгол Улсын ГХЯ, Үндэсний статистикийн хороо болон НҮБ-ын Шилжилт хөдөлгөөний байгууллагаас зохион байгуулсан “Гадаад улсад оршин суугаа Монгол Улсын иргэдийн нөхцөл байдал” судалгаа 2023 оны 6 сард зохион байгуулагдаж өндөрлөснийг энд цохон тэмдэглэх нь зүйтэй.

Түлхүүр үгс: Шилжилт хөдөлгөөн, олон улсын шилжилт хөдөлгөөн, Монгол Улс.

2. СУДАЛГААНЫ ОНОЛ

Шилжилт хөдөлгөөний талаарх ерөнхий ойлголт

Хүн амын шилжилт хөдөлгөөн (migration)-ий үндсэн ойлголт нь түр болон урт хугацаагаар суурьших зорилготойгоор нэг газраас нөгөөд шилжих хувь хүн ба бүлэг хүмүүсийн хөдөлгөөнөөр тодорхойлогддог.⁵ Олон улсын түвшинд шилжилт хөдөлгөөний талаар нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн тодорхойлолт байхгүй хэдий ч цөөн хэдэн эх сурвалжаас боловсруулан гаргасан тодорхойлолтыг ашиглаж болно хэмээн үздэг байна.⁶ Тухайлбал, НҮБ-ын Эдийн засаг нийгмийн харилцааны асуудал эрхэлсэн газраас /ЭЗНХАЭГ/ 1998 онд гаргасан “Олон улсын шилжилт хөдөлгөөний статистикийн зөвлөмж”, ОУШХБ-ын тодорхойлолт зэргийг дурдаж болно.

2 “ДЭЛХИЙН МОНГОЛЧУУД” ХӨТӨЛБӨР /БҮРЭН ЭХЭЭРЭЭ/. (2016) <https://mfa.gov.mn/32520>

3 “Зөгийн үүр” хөтөлбөрийн тухай <https://sites.google.com/site/scprojectteam/my-page>

4 Damdinsuren, Oyunsuren, “BRAIN DRAIN OR BRAIN GAIN: THE CASE OF MONGOLIA”. (2011): p.13

5 Enni Kallio. “Human Migration: Implications and Opportunities for Conservation”, (2016): p.6


6 IOM’s World Migration Report 2020 (IOM, 2020): p.5

7 “Who is a migrant?” <https://www.iom.int/node/102743>

Энэхүү нэр томъёог бүрэн дүүрэн ойлгохын тулд шилжилт хөдөлгөөнийг зохицуулах салбарт тэргүүлэн ажилладаг НҮБ-ын төрөлжсөн байгууллага болох Олон улсын шилжилт хөдөлгөөний байгууллагын (ОУШХБ) тодорхойлолтыг авч үзэх нь зүйтэй. Тус байгууллага нь энэхүү ойлголтыг “Хүн амын шилжилт хөдөлгөөн гэдэг нь олон улсын хил давсан эсвэл тухайн улс доторх хувь хүн, бүлэг хүмүүсийн шилжилт хөдөлгөөнийг хэлэх бөгөөд энэ нь оршин суух хугацаа, шилжих шалтгаанаас үл хамааран хүмүүсийн аливаа төрлийн шилжилт хөдөлгөөнийг хамарсан үйл явц юм. Үүнд дүрвэгсэд, цагаачид, эдийн засгийн цагаач, болон гэр бүлээ нэгтгэх зэрэг бусад зорилгоор шилжин суурьшиж буй хүмүүсийн шилжилт хөдөлгөөн багтана.”⁸ хэмээн тодорхойлсон байдаг.

Шилжилт хөдөлгөөний түүхэн үе шат

Шилжилт хөдөлгөөний түүх нь Африкийн Рифтийн хөндийд хүн төрөлхтөн үүссэн үеэс эхэлсэн бөгөөд тэр газраас МЭӨ 200 000-с МЭӨ 5000 орчим онуудын хооронд өнөөгийн оюун ухаант хүний өвөг болох Хомо Сапиенсууд Европт, дараа нь бусад тивд тархсан билээ.⁹ Хүн төрөлхтөн шинэ боломжуудыг эрэлхийлэхийн тулд шилжилт хөдөлгөөн хийх болсон бөгөөд ихэнх тохиолдолд нийгмийн болон хүрээлэн байгаа орчин дахь нөхцөл байдал доройтсоноос болоод нүүж байв.¹⁰ Ийнхүү хүмүүс дэлхий даяар тархаж, зарим хэсэг нь ургамал амьтан ихтэй, цаг уурын хувьд тааламжтай газруудыг нээн илрүүлэх болсноор хүмүүс аажмаар нүүдэллэхээ больж суурьших болжээ.



Зураг 2: Хүн төрөлхтний эртний шилжилт хөдөлгөөн.
Эх сурвалж: National Geographic Image Collection

Шилжилт хөдөлгөөнд нөлөөлөгч хүчин зүйлс

Лондонгийн Их Сургуулийн профессор Ричард Блэк (Richard Black) 2011 онд хэвлүүлсэн “Шилжилт хөдөлгөөн ба дэлхийн байгаль орчны өөрчлөлт – Шилжин суурьшилтад нөлөөлөгч зүйлсийн тойм” (Migration and Global Environmental Change – Review of Drivers of Migration) эрдэм шинжилгээний өгүүлэлдээ хүний шилжилт хөдөлгөөний чиглэл, давтамжид нөлөөлдөг макро түвшний таван хүчин зүйлийг тодорхойлсон. Үүнд: улс төр, хүн ам зүй, эдийн засаг, нийгэм, байгаль орчны хүчин зүйлс багтана.¹¹ Хүн амын шилжилт хөдөлгөөнд нөлөөлөгч таван хүчин зүйлээс эдийн засаг, хүн ам зүйн хүчин зүйлүүд дэлхийн хүн амын шилжилт хөдөлгөөнд хамгийн их нөлөөлдөг хэмээн Калифорнийн их сургуулийн (University of California) судлаач Филип Мартин (Philip Martin) үзсэн байна.¹² Гэсэн хэдий ч эдгээр таван хүчин зүйлс нь дангаараа шилжилт хөдөлгөөнийг бий болгох нь маш ховор тохиолдол бөгөөд, харин аливаа хувь хүн,

8 International Organization for Migration. “Glossary on Migration”, (2019): p.137

9 Koser, Khalid. “International migration: a very short introduction”. Oxford University Press. (2007): p.1

10 Fisher, M. H. “Migration: A world history.” Oxford University Press. (2014): p. 12

11 Black, Richard & Adger, W. & Arnell, Nigel & Dercon, Stefan & Geddes, Andrew & Thomas, David. “Migration and Global Environmental Change. Global Environmental Change-human and Policy Dimensions”. (2011)

12 Martin, P. ‘The Global Challenge of Managing Migration’. Population Bulletin, Population Reference Bureau. (2013).

бүлэг хүмүүсийн шилжилт хөдөлгөөний шийдвэрт нөлөөлөхийн тулд янз бүрийн түвшинд өөр хоорондоо нягт уялдаатайгаар хамтран ажилладаг.

Олон улсын шилжилт хөдөлгөөний өнөөгийн байдал

2020 онд дэлхий даяар 281 сая орчим хүн олон улсын цагаач гэсэн статустай байсан бөгөөд энэ нь дэлхийн хүн амын 3.6 хувьтай тэнцэх тоо юм.¹³ Энэхүү үзүүлэлтийг дэлхийн нийт хүн амтай харьцуулбал шилжилт хөдөлгөөн хийж байгаа хүмүүс нийт хүн амын маш бага хувь байгаагаас төрсөн эх орондоо үлдэж, суурьших нь олон нийтийн жишиг хэвээр байсаар байгааг харуулж байна. Гэсэн хэдий ч жил ирэх тусам олон улсын шилжилт хөдөлгөөн цар хүрээгээ улам тэлсээр байгаа бөгөөд 2050 он гэхэд олон улсын цагаачдын тоо 330.9 сая болж нэмэгдэх хандлагатай байна.¹⁴

3. СУДАЛГАА, ҮР ДҮН

Монгол Улсын олон улсын шилжилт хөдөлгөөний өнөөгийн байдал

Монгол Улс ардчилсан тогтолцоонд шилжсэн 1990 оноос Монгол Улсын иргэд гадаадын улс орнууд руу зорчиж, дэлхийн өнцөг булан бүрт ажиллаж, амьдарч, сурч, мөн суурьшсан амьдрах болсноос хойш Монгол руу чиглэсэн шилжилт хөдөлгөөнтэй харьцуулбал Монголоос гадагшаа чиглэсэн шилжилт хөдөлгөөн хол давсан үзүүлэлттэй бөгөөд, мөн судалгааны ажлын зорилгынхоо хүрээнд гадагш чиглэх буюу хилийн чанад дахь Монголчуудын талаарх судалгаанд илүү төвлөрсөн болно.

НҮБ-ын Олон улсын шилжилт хөдөлгөөний статистикаас үзвэл 2019 оны байдлаар 73 488 хүн,¹⁵ үүнийг Монгол Улсын статистиктай харьцуулбал 2015 оны байдлаар 120 мянган иргэн хилийн чанадад оршин суугаа судалгаа байдаг¹⁶ бөгөөд энэ тоо нь манай улсын нийт хүн амын 4 хувийг эзэлж байсан юм. Үүнтэй харьцуулахад ГХЯ-аас гаргасан тоон мэдээллээр 2019 оны жилийн эцсийн байдлаар /2019.12.31/ гадаадад 197000 мянган Монгол иргэд оршин сууж байгаа¹⁷ гэвэл дөрвөн жилийн хугацаанд хилийн чанадад оршин суугаа иргэдийн тоо 40 хувиар өссөн бөгөөд нийт хүн амын 6 орчим хувь болж өссөн байна.

Дээрх тоон мэдээлэл өөр хоорондоо зөрж байгаа нь улс орнуудын мэдээлэл цуглуулах, боловсруулах аргачлалууд харилцан адилгүй байдаг, мөн улс орнуудын тооллого хийх давтамж өөр хоорондоо зөрдөг зэргээс үүдэлтэй юм. Монгол Улсын хувьд 10 жил тутам хийгддэг хүн амын тооллогоор 2010 онд 107 140 иргэд гадаадад оршин сууж байснаас 51 гаруй хувийг нь мэргэжил эзэмшсэн, хөдөлмөр эрхлэх насны иргэд эзэлж байв.¹⁸ Харин хүн ам, орон сууцны 2020 оны ээлжит тооллогын дүнгээр гадаадад оршин суугаа 122 301 иргэн тоологдож 2010 оноос 14.2 хувиар өсжээ.

Хэрэв ГХЯ-ны тоон мэдээлэл болох нийт 197 000 монголчууд хилийн чанадад ажиллаж, амьдарч байна гэж үзвэл, энэхүү тоо баримтыг нягталбал: АНУ-д 40.1 мянга, ЕХ-ны улсуудад 43.7 мянга, БНСУ-д 50.8 мянга, Япон улсад 16.3 мянга, Австрали улсад 7.0 мянга, харин 39.1 мянган Монголчууд бусад орнуудад тус тус оршин сууж байна.¹⁹

13 UN DESA. "International Migrant Stock 2020: Destination and origin" 2020a: p.1

14 M.Hofmann, A.Jolivel, D.Huss, C.Ambiaux. "International Migration: Drivers, Factors and Megatrends". (March, 2020): p.2

15 United Nations, Department of Economic and Social Affairs, Population Division (2019): International Migrant Stock 2019 <https://www.un.org/en/development/desa/population/migration/data/estimates2/estimates19.asp>

16 Үндэсний статистикийн хороо. "Үндсэн үзүүлэлтүүд 2015" <http://www.nso.mn>

17 Монгол Улсын Гадаад Харилцааны Яам. "Түгээмэл асуулт, хариулт" <https://mfa.gov.mn/faq>

18 Монгол Банк, Чех улс дахь Монголчуудын Холбоо. "БНЧУ-д ажиллаж, амьдарч буй Монгол иргэдийн мөнгөн гуйвуулгын хэмжээг тооцоолох түүвэр судалгаа" (2012): p.2

19 Home Mortgage Corporation. "Гадаадад ажиллаж, амьдарч буй иргэдийн тоо". <http://hmc.mn/medee/v/6?fbclid=IwAR1PULuLkzhgpCfdDPbTQqaoHwBK7J0j7BdOtlr9R6oUrmyOzbyVuGdja WY>

Дэлхийн банкнаас гаргасан судалгаагаар хилийн чанадад байгаа Монголчууд 2020 онд

548.8 сая ам.долларыг эх орон руугаа шилжүүлсэн ба энэ нь ДНБ-ий 4.2%-тай тэнцэж байна.²⁰ Гэвч энэ бол зөвхөн банк болон мөнгөн гуйвуулгын системээр дамжин ирсэн албан ёсны бүртгэлтэй мөнгөн дүн бөгөөд бүртгэлгүй бусад сувгуудаар эх орон руугаа шилжүүлсэн мөнгөн гуйвуулгын хэмжээ бодит байдал дээр дээрх үзүүлэлтийг хол давна. Монгол Улсын нийт татварын орлого 9.2 их наяд төгрөг²¹ байгаагаас 65.3%-ийг ТОП 100 ААН бүрдүүлдэг.²² Тэгвэл гадаадад байгаа Монголчуудын шилжүүлсэн мөнгөн гуйвуулгын хэмжээ нийт татварын орлогын 16.6%-тай тэнцэж байна. Өөрөөр хэлбэл хилийн чанад дахь монголчууд Монгол Улсын ДНБ-ий дор хаяж 4.2%-ийг бүрдүүлдэг манай улсын идэвхтэй баялаг бүтээгчид юм.

Монгол Улс дахь олон улсын шилжилт хөдөлгөөний тулгамдсан асуудал

Дэлхийн банкны шилжилт хөдөлгөөн ба хөгжлийн товч мэдээний тооцоогоор 2021 онд бага, дунд орлоготой орнууд руу гуйвуулсан мөнгөний хэмжээ өнгөрөгч оныхоос 7.3 хувиар өсөж, 589 тэрбум долларт хүрэх төлөвтэй байна.²³ Ийнхүү хоёр дахь жилдээ бага, дунд орлоготой орнууд руу илгээсэн мөнгөн гуйвуулгын урсгал нь гадаадын шууд хөрөнгө оруулалт (Foreign Direct Investment – FDI) болон хөгжлийн албан ёсны тусламжийн (Official Development Assistance - ODA)²⁴ дүнгээс давж байгаа юм. Тухайлбал 2019 онд бага, дунд орлоготой орнууд руу илгээсэн мөнгөн гуйвуулгын урсгал нь 548 тэрбум ам.долларт хүрч түүхэнд урьд өмнө нь байгаагүй үзүүлэлтийг харуулсан бол, гадаадын шууд хөрөнгө оруулалтын урсгал 534 тэрбум ам.доллар харин хөгжлийн албан ёсны тусламж 166 тэрбум ам.доллар байсан.²⁵ Эдийн засгийн хүндрэлтэй үед, тэр тусмаа дэлхий нийтийг хамарсан цар тахлын үед, цагаачдын илгээж буй мөнгөн гуйвуулга эх оронд нь хоол хүнс, эрүүл мэнд, боловсрол зэрэг нэн шаардлагатай зүйлсэд өрхийн зарцуулалтыг дэмжих замаар амьдралын чухал хэрэгцээг хангахад чухал үүрэг гүйцэтгэдэг.

Тиймээс цаашид Монгол улсын олон улсын шилжилт хөдөлгөөнд тулгамдаж буй асуудлыг судлаж, нөхцөл байдлыг сайжруулах боломж боллоцоо, нөхцөлүүдийг тодруулахад холбогдох мэргэжилтнүүдийн байр суурь болон олон нийтийн ерөнхий хандлага, дэмжлэгийн байдлыг илрүүлэх шаардлага тулгарч байна.

Үүний хүрээнд түүврийн аргаар сонгосон 250 орчим хүнийг хамарсан санал, асуулга болон олон улсын шилжилт хөдөлгөөнийг чиглэлийн ээр судалгаа шинжилгээний чиглэлийн мэргэжилтнүүдтэй ярилцсан ярилцлага, дүгнэлт, санал бүхий хоёр хэсгээс бүрдсэн судалгааг явуулав.

Судалгааны үр дүн

Монгол Улсын олон улсын шилжилт хөдөлгөөний өнөөгийн байдлыг тодорхойлох зорилго бүхий нийт 14 асуулттай асуулга 23 оронд тархан суурьшсан нийт 232 хүнээс 2021 оны 11-р сарын 18-наас 12-р сарын 2-ны өдөр хүртэл нийт хоёр долоо хоногийн хугацаатайгаар явуулсан.

20 The World Bank. "Personal remittances, received (% of GDP)- Mongolia" (2010-2020) <https://data.worldbank.org/indicator/BX.TRF.PWKR.DT.GD.ZS?end=2020&locations=MN&start=2010&view=chart>

21 OECD "Details of Public Revenue-Mongolia" <https://stats.oecd.org/Index.aspx?DataSetCode=REVMNG>

22 Б.Делгөөн. "Монгол Улсын ТОП 100 ААН ба онцлох үзүүлэлтүүд" (2020) <https://ikon.mn/n/lvxf>

23 The World Bank. "Migration and Development Brief 33". <https://www.worldbank.org/en/topic/socialprotectionandjobs/publication/migration-and-development-brief-33>


24 Хөгжлийн албан ёсны тусламж (ODA) нь хөгжиж буй орнуудын эдийн засгийн хөгжил, сайн сайхан байдлыг дэмжих зорилготой засгийн газрын тусламж ба үүнд цэрэг армийн зориулалттай зээл, тусламжийг оруулдаггүй болно.

25 The World Bank. "Remittance flows register robust 7.3 percent growth in 2021". (Nov 17, 2021). <https://www.worldbank.org/en/news/press-release/2021/11/17/remittance-flows-register-robust-7-3-percent-growth-in-2021>

Хүснэгт 1: Судалгааны хамрах хүрээ


№	Хамрах хүрээ	Түүврийн хэмжээ		№	Хамрах хүрээ	Түүврийн хэмжээ	
		Тоо	Хувь			Тоо	Хувь
1	АНУ	80	34.4 %	13	Испани	4	1.7 %
2	Франц	47	20.2 %	14	Австри	3	1.3 %
3	Их Британи	14	6.0 %	15	Энэтхэг	3	1.3 %
4	Швед	12	5.2 %	16	Хятад	2	0.9 %
5	БНСУ	12	5.2 %	17	Япон	2	0.9 %
6	Канад	11	4.7 %	18	Словак	2	0.9 %
7	Герман	8	3.4 %	19	Дани	1	0.4 %
8	Унгар	7	3.0 %	20	Сингапур	1	0.4 %
9	Швейцарь	6	2.6 %	21	Итали	1	0.4 %
10	Австрали	5	2.2 %	22	Шинэ Зеланд	1	0.4 %
11	Чех	5	2.2 %	23	Казахстан	1	0.4 %
12	Бельги	4	1.7 %				
Нийт						232	100.0%

Эх сурвалж: Зохиогч



Зураг 3:

Судалгаанд оролцогчдын насны байдал



Зураг 4:

Судалгаанд оролцогчдын хүйсийн байдал

Монголоос явах болсон шалтгааныг эрэмбэлбэл:

Амьдрах орчноо дээшлүүлэх-49.1%, Ажил хөдөлмөр эрхлэх-46.6%, Сурч боловсрох-43.5%, Монгол Улс дахь эдийн засгийн тогтворгүй байдал-31%, Монгол Улс дахь хууль эрх зүйн тэгш бус байдал-26.3%, Хүүхдээ сургуульд сургахын тулд-27.2%, Төрийн дарамт шахалт- 8.2% гэж тус тус хариулсан байна.

Судалгаанд оролцогчид Монгол дахь амьдралын нөхцөлөө сайжруулах шалтгаанаар голчлон шилжилт хөдөлгөөн хийсэн бөгөөд, үүний дараагаар ажил хөдөлмөр эрхлэхээр явсан байна. Үүнээс үзэхэд, Монгол Улсын хувьд шилжилт хөдөлгөөн хийх гол түлхэх хүчин зүйлс бол иргэдийн амьжиргааны түвшин доогуур буюу амьдралын өртөг өндөр, мөн дундаж цалингийн хэмжээ бага гэдгийг илэрхийлж байна.

Харин “Суурьшин амьдрахаар шийдсэн шалтгаан”-ы талаар 71.6% “Орлого, ажил хөдөлмөр” гэсэн нь давуу хариулт өгсөн байна.




График 1: Хилийн чанадад суурьшиж амьдрах болсон шалтгаан

Дээрх үзүүлэлтээс харахад гадаадын орнууд, тэр дундаа дийлэнх оролцогчдын амьдарч байгаа хөгжингүй орнуудад дундаж цалингийн хэмжээ өндөр, хүн өөрийн хөдөлмөрийг бодитоор, шударгаар үнэлүүлж чаддаг, амьжиргааны түвшин өндөр, мөн Монголд хамгийн их дутагддаг зүйл болох хүний амьдрах орчин буюу агаар, орчны бохирдолгүй гэсэн эдгээр татах хүчин зүйлс байдаг гэсэн дүр зураг харагдаж байна.

Монгол Улсын талаарх мэдээ мэдээллийг “Нийгмийн сүлжээ” 74.7%, 11.6% нь “Хэвлэл мэдээлэл” болон 12% нь “Монгол дахь гэр бүл, найз нөхөд” - с авдаг бөгөөд дийлэнх нь эх орондоо буцаж суурьших хүсэлгүй байгаа нь Монгол Улс гадаад дахь Монголчуудын хувьд татах хүчин зүйлсээс илүү түлхэх хүчин зүйлс ихтэй байгааг харж болно.




График 2: Хилийн чанадад амьдарч байх хугацаанд хамгийн их тулгарсан асуудлууд

Судалгаанд оролцогчдоос 51.3% нь Хэлний бэрхшээл, 47% нь Монгол Улсын ЭСЯ-ны зүгээс иргэддээ үзүүлэх дэмжлэг сул, 33.6% нь Суугаа улсынхаа талаарх хууль эрх зүйн зөвлөгөө авах боломж хомс, 24.6% нь Монголын талаарх бодит, үнэн зөв мэдээ, мэдээлэл дутмаг”, 15.9% нь Иргэдийн нэгдсэн бүртгэл, эргэх холбоо сул гэх хариултуудыг өгсөн.




График 3: Монголд буцаж суурьшихад тулгардаг гол асуудлууд

Монгол Улсад буцаж суурьшихад тулгардаг гол асуудлуудын хувьд 75% Цалингийн дундаж хэмжээ, 67.2% Амьдрах орчин, 64.7% Эдийн засгийн тогтворгүй байдал, 57.3% Хоол хүнсний аюулгүй байдал, 55.2% Эрүүл мэндийн систем, 46.6% Хууль эрх зүйн орчин, 44.4% Сургууль, цэцэрлэгийн чанар, 28.4% Төрийн шахалт, дарамт гэсэн хариултыг өгсөн. Үүнээс харвал судалгаанд оролцогчдын дунд эдийн засгийн хүчин зүйлсээс болж тухайлбал, цалингийн дундаж хэмжээ, эдийн засгийн тогтвортой байдлыг эрэлхийлэн эх орон руугаа буцаж ирэхээс татгалзаж байгаа нийтлэг хандлага ажиглагдаж байна.

Мөн 51.6% нь гадаадад амьдарч байхад нь туслалцаа илүү үзүүлэх, харин 48.4% нь гадаад дахь Монголчуудыг буцааж ирүүлэхэд анхаарах гэсэн хариултыг өгсөн.

Хүснэгт 2: Хилийн чанад дахь Монголчуудад төр засгаас ямар дэмжлэг хамгийн их хэрэгтэй байдаг талаар

Чиглэл	Тулгамдсан асуудлууд	Хувь
ЭСЯ-дуудын үйл ажиллагааг сайжруулах чиглэлээр	ЭСЯ-ны хүнд суртал, харилцаа, үйлчилгээ хэцүү	32%
	ЭСЯ-ны үйлчилгээг цахим болгох, үнэн зөв мэдээллээр тогтмол хангах	
	Гадаадад байгаа Монголчуудыг оролцуулсан арга хэмжээ, үйл ажиллагаа идэвхтэй явуулах /Монголчуудын хоорондын сүлжээг бат бөх болгох, Монголчуудын холбоо зэргийг дэмжиж, үйл ажиллагаа явуулахад туслах/	
	Гадаадад бизнес эрхлэхэд дэмжих	
	Шинэ орчинд дасах, хууль, эрх зүйн зөвлөгөө мэдээллээр хангах	
Төрийн бодлого, үйлчилгээний чиглэлээр	Эх орондоо хөрөнгө оруулалт хийх, тусламж явуулах боломжийг хангах	41%
	Монгол дахь иргэдтэй адил төрийн үйлчилгээ авах боломж	
	Гадаад дахь иргэдтэйгээ эргэх холбоотой байх, Төрийн үйлчилгээг цахим болгох	
	Сонгуульд оролцох идэвхийг нэмэгдүүлэх	
	Эх орондоо хөрөнгө оруулалт хийх, тусламж үзүүлэхэд татвараар дэмжих	
	Гадаадад ажиллаж байгаа жилийг нь хөдөлмөрийн дэвтэрт бичих, тэтгэвэр гарахад ажилласан жилийг нь тооцох	
Давхар иргэншилтэй болох	Төрөөс үзүүлж байгаа бодлого, түүний чадвар сул байдал, шударга бус, найдваргүй байгаа иргэдээ дэмжсэн цогц бодлого хэрэгтэй талаар	
Төрөөс үзүүлж байгаа бодлого, түүний чадвар сул байдал, шударга бус, найдваргүй байгаа иргэдээ дэмжсэн цогц бодлого хэрэгтэй талаар		

Хүний эрхийн асуудлаар	Гадаадад амьдарч байх үед нь үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх боломж, нөхцөл	3%
	Гадаадад байгаа иргэдээ улсынхаа иргэд биш мэтээр хүлээн авч, ялгаварлан гадуурхах байдлыг арилгах	
	УИХ-д гадаад дахь иргэдийн төлөөллийг оруулах	
Хилийн чанад дахь иргэд эх орондоо буцаж ирэх нөхцөлийг бүрдүүлэх чиглэлээр Мэдээллээр хангах чиглэлээр	Монгол Улсад ажиллах боломж, баталгаат ажлын байр, бизнес эрхлэх боломж	44%
	Монгол Улс иргэддээ ээлтэй, тэгш хүртээмжтэй нийгмийг бүрдүүлэх	
	Хууль эрх зүйн орчинг дээшлүүлэх /тэгш бус байдал/	
	Монголдоо сурч боловсрох таатай орчинг бүрдүүлэх -Чанартай боловсрол	
	Монгол дахь эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг сайжруулах	13%
	Цалингийн хэмжээг нэмэгдүүлэх	
	Монголд орон сууц авах, газар өмчлөхөд дэмжлэг үзүүлэх	
	Монгол Улсыг дэлхийн тавцанд сурталчилах, Монгол бахархлыг иргэдэд өгөх	
	Монголд бизнес эрхлэхэд дэмжлэг үзүүлэх	
	Үнэн зөв мэдээллээр тогтмол хангах	
	Хууль эрх зүйн зөвлөгөө, мэдээллээр хангах	
	Сонгуультай холбоотой мэдээллээр хангах	

Эх сурвалж: Зохиогч

Судалгааны хоёрдугаар хэсэгт НҮБ-ын Шилжилт хөдөлгөөний байгууллагын /International Organization for Migration/ мэргэжилтнүүд болох Хөтөлбөрийн удирдагч Виктор Лутенко (Victor Lutenco), хөтөлбөрийн ажилтан М.Бямбасүрэн болон төслийн ажилтан С.Мөнхчулуун нартай тус бүр 50-80 минутын ганцаарчилсан дэлгэнгүй ярилцлага хийсэн.

Салбарын голлох мэргэжилтнүүдийн ярилцлагыг нэгтгэн боловсруулахад:

Монголчуудын гадаад руу чиглэсэн шилжилт хөдөлгөөн хийх үндсэн шалтгаанууд:

- амьжиргаагаа дээшлүүлэхийн тулд хөдөлмөр эрхлэхээр явах
- мэдлэг чадвараа дээшлүүлэхийн тулд сурах

Хилийн чанадад байгаа Монголчуудад тулгамддаг гол асуудлууд:

- ЭСЯ болон КГ-уудын үйл ажиллагааны чанар болон хүртээмж
- Монгол руу очих нислэг цөөн
- Хилийн чанад дахь Монголчуудыг 100% хариуцан ажилладаг төрийн байгууллага Монголд байдаггүй
- Сонгууль өгөх эрхийнх нь хүрээнд сонгууль өгөх боломж бололцоо муу
- Мөнгөн гуйвуулгын шимтгэл өндөр, шилжүүлэхэд хамгийн түргэн шуурхай, хялбар, хямд аргаар шилжүүлэх нөхцөлийг нь бүрдүүлж өгөх, албан бус гуйвуулгын сувгаар үүсч болох эрсдлээс иргэдээ хамгаалах зэрэг зохицуулалтыг хийж өгөх нь зүйтэй.

Монголчууд эх орондоо буцан ирж амьдрахад тулгамддаг бэрхшээл, сорилт:

- “харласан” буюу визний хугацаагаа хэтрүүлэн амьдарч байсан хүмүүс эх орон руугаа буцахад өндөр хэмжээний торгууль төлөх болдог
- Буцаж ирсэн иргэдэд reintegration буюу нийгэмшиж чадахгүй байх асуудал үүсдэг.
- Монголын нийгмийн нөхцөл байдал, ажлын байр, эдийн засаг улам дордоод байгаа юм шиг гадаадад байгаа Монголчуудын нүдээр харагдаж байгаа болохоор буцаж ирэхгүй байх хандлагатай

Гадаад дахь Монголчуудтай холбоотой Монгол Улсын ЗГ-с хэрэгжүүлдэг бодлого, хөтөлбөр, тэдгээртэй холбоотой тулгамдсан асуудлууд:

- Монголын ЗГ-ын зүгээс Консулын газраас сайн үйлчилгээ үзүүлэх, нислэгийн тоог нэмэх, сонгууль өгөх эрхийг өгөх гэх зэрэг илүү өргөн хүрээг хамарсан хөтөлбөр хэрэгтэй Монгол Улс болон Хилийн чанад дахь Монголчуудын хооронд харилцан итгэлцэл үүссэний дараагаар харилцан ашигтай байдал, хувь нэмрийн талаар ярих
- Давхар иргэншлийг асуудлыг хэлэлцэх
- Төсөл хөтөлбөрүүд мэдлэг мэдээллээр дамжуулан хүмүүсийг эрсдэл, аюулд орохоос нь урьдчилан сэргийлэх
- Монгол хэл дээрх мэдлэг, мэдээлэл их дутмаг байдаг
- Нэгдсэн мэдээллийн порталтай болох
- Хүн болгон өөрсдийн онцлог, сонирхолын дагуу хамрагдах боломжтой маш олон төрлийн хөтөлбөр, төслүүдийг хэрэгжүүлэх
- Ямар төрлийн хүмүүс нь Монголдоо ирвэл илүү хувь нэмэртэй болох, ямар хүмүүс тэндээ байвал илүү хувь нэмэртэй гэдгийг тодорхойлон монголд авчрах, эсвэл тэнд нь дэмжих талаар хосолсон бодлого хэрэгжүүлэх

Монгол Улсын хувьд яг одоо ОУШХ-ний тулгамдаж байгаа асуудал:

- Гадаад дахь Монголчуудад хангалттай анхаарал хандуулдаггүй нь өөрөө асуудал
- Хилийн чанад дахь Монголчуудын талаарх ойлголтыг нэмэгдүүлж, тэднийг судлах Түүврийн аргаар авсан хаалттай, нээлттэй асуулга, мэргэжилтнүүдийн ярилцлага санал дүгнэлтүүдийг нэгтгэн боловсруулхад хариултууд давхцаж байсан.

Судалгааны үр дүнг боловсруулхад гадаад дахь Монгол иргэд тодорхой нөхцөлүүд хангагдсан тохиолдолд эх орондоо буцаж ирэх хүсэлтэй байдаг бөгөөд, үүнд баталгаат ажлын байр, бизнес эрхлэх боломж, цалингийн зөрүүг арилгах, иргэдэд ээлтэй нийгмийг бүрдүүлэх мөн гадаадад амьдарч байх үед нь тэдэнд чиглэсэн төрийн цогц бодлого хэрэгтэй талаар, өөрөөр хэлбэл гадаад улсад байхдаа ч гэсэн эх оронтойгоо эргэх холбоотой байх, төрийн үйлчилгээг Монгол дахь иргэдтэй ижил тэгш авах, улс төрийн идэвхтэй байх зэрэг болно. Гуравдахь тулгамдсан асуудал нь Монгол Улсыг төлөөлөн тухайн оронд суугаа ЭСЯ-дуудын үйл ажиллагааг сайжруулах, эх оронтойгоо холбогдоход нь гүүр болох зэрэг асуудлаар саналаа ирүүлсэн. Мөн үнэн зөв мэдээллээр тогтмол хангагдах, хүний эрхийн асуудлыг хөндсөн.

Үүнээс дүгнэн үзвэл хилийн чанад дахь Монголчууд эх орондоо буцаж ирэхийг эрмэлзэж байдаг, мөн гадаадын улс оронд амьдарч байхдаа төрийн бодлого, үйлчилгээг авах замаар эх оронтойгоо холбоотой байхыг хүсдэг, мөн ЭСЯ-аар дамжуулан эх орондоо хөрөнгө оруулах, дэмжлэг авах хүсэл сонирхолтой байдаг нь судалгаагаар харагдлаа.

4. ДҮГНЭЛТ, САНАЛ ЗӨВЛӨМЖ

Судалгааны ажлын хүрээнд олон улсын шилжилт хөдөлгөөний талаар судлах, энэ сэдвийн ач холбогдлыг гаргаж ирэх, цаашлаад хилийн чанад дахь Монголчуудад тулгамдаж буй асуудлыг олж илрүүлэх зорилго тавьсан бөгөөд эл зорилгынхоо хүрээнд олон улсын шилжилт хөдөлгөөний өнөөгийн байдал, зохицуулалтыг таньж мэдэх, хилийн чанад дахь Монголчуудад тулгамддаг асуудлуудыг илрүүлж тогтооход чиглэх зорилтууд тавьж судлав. Монгол Улсын олон улсын шилжилт хөдөлгөөний өнөөгийн байдлын талаар судалгааны холимог арга ашиглан, 232 хүнээс түүвэр судалгаа хийж, ОУШХБ-ын мэргэжилтнүүдээс ярилцлагын аргаар ярилцлага авч өнөөгийн байдал, тулгамдсан асуудлуудыг тодорхойлохыг эрмэлзлээ.

Монгол Улсын нийт хүн амын 6%-ийг эзэлж байгаа хилийн чанад дахь Монголчууд амьжиргааны түвшнээ дээшлүүлэх, мэдлэг боловсрол эзэмших зорилгоор зорчиж улмаар амьдралын таатай орчины улмаас тэндээ үргэлжлүүлэн амьдардаг бөгөөд явсан иргэдийн 60% нь эх орондоо буцаж ирэх хүсэлгүй, буцаж ирэхгүй гэсэн шалтгаанаар Монгол Улсын улс төрийн тогтворгүй байдал, эдийн засаг бизнесийн дарамт, шүүх засаглалын шударга бус байдал, амьдрах таатай орчин хангагдахгүй байх, эрүүл мэнд ба боловсролын систем сул, цалингийн дундаж хэмжээ харьцангуй бага зэрэг шалтгаануудыг онцолжээ.

Мөн судалгаанд оролцсон иргэд болон мэргэжилтнүүдтэй ярилцсан ярилцлагад үндэслэн харахад гадаад дахь Монголчууд амьдралын наад захын стандарт хангагдсан тохиолдолд буцан ирж суурьшин, өөрсдийн боловсрол, мэдлэг туршлагаараа эх орондоо хувь нэмрээ оруулах чин хүсэлтэй байдаг нь харагдсан. Тэд энэ хүслээ өвөрлөн гадаад дахь Монголчуудад чиглэсэн цогц бодлого хэрэгжүүлэхийг төр засгаас хүсэмжилдэг бөгөөд хилийн чанадад олон жил амьдарсан иргэд итгэл найдвар алдран тэндээ үлдэж суурьших, үр хүүхдээ хөгжингүй орны амьдрах таатай орчинд өсгөж хүмүүжүүлэх шийдвэрийг гаргадаг байна.

Санал зөвлөмж: Монгол Улс нийт хүн амынхаа тоогоор дэлхийд 136-д жагсдаг, идэвхтэй ажиллах хүчний насны 1.1 сая хүн амтай орон. Гэтэл хөгжингүй орнуудад сурч, ажиллахаар явсан иргэд, тэдний гэр бүл, үр хүүхэд тухайн оронд ууссанаар идэвхитэй хөдөлмөр эрхлэх насны баялаг бүтээх боломжит иргэдээ алдах аюул нүүрлээд байна. Иймээс төр засгаас гадаад дахь Монголчуудыг хариуцан ажилладаг байгууллага, цогц бодлоготой байх, тэнд амьдарч байхад нь эргэх холбоотой байх, төрийн үйлчилгээгээр эндэх иргэдтэй адил тэнцүү хандах, улс төрийн идэвх оролцоог нэмэгдүүлэх, хөрөнгө оруулалтын таатай нөхцөлийг бүрдүүлэх, улс орондоо хувь нэмрээ оруулах боломжийг бүрдүүлэх зэргээр эх оронтой нь уях нь эргээд тэдний мэдлэг боловсрол, туршлагыг хүртэх, Монгол руу чиглэсэн мөнгөн урсгалыг нэмэгдүүлэх гэх зэрэг эдийн засаг, нийгмийн олон давуу байдлууд бий болох боломжтой юм.

Оюутны төрөлд тэргүүн байранд шалгарсан судалгаа:

МОНГОЛ УЛСАД БУЦАН ИРЭХ ШИЛЖИЛТ ХӨДӨЛГӨӨНИЙ ӨНӨӨГИЙН ХАНДЛАГА, ТӨЛӨВ БАЙДАЛ

- Зохиогч:** **Г.Мягмарцэрэн**, Монгол Улсын Их Сургуулийн Шинжлэх Ухааны Сургуулийн Нийгмийн Ухааны Салбарын Эдийн засгийн тэнхмийн 4-р түвшний оюутан
Цахим шуудан: mmigaa0327@gmail.com
Утасны дугаар: 88206491
- Зохиогч:** **О.Цэнгүүн**, Монгол Улсын Их Сургуулийн Шинжлэх Ухааны Сургуулийн Нийгмийн Ухааны Салбарын Эдийн засгийн тэнхмийн 4-р түвшний оюутан
Цахим шуудан: tsenguunagar@gmail.com
Утасны дугаар: 95355912
- Удирдсан багш:** **Б.Мөнхжаргал**, Монгол Улсын Их Сургуулийн Шинжлэх Ухааны Сургуулийн Нийгмийн Ухааны Салбарын Эдийн засгийн тэнхмийн ахлах багш

Хураангуй

Монгол Улсад хүн амын орчин үеийн гадаад шилжих хөдөлгөөн эхлээд 30 аад жил өнгөрч байгаа ч холбогдох судалгааны ажлууд харьцангуй хангалтгүй байсаар байна. Сүүлийн жилүүдэд Монгол улсад дотоодын шилжих хөдөлгөөний асуудалд голцуу анхаарал хандуулж, гадаад буцан шилжих хөдөлгөөнийг орхигдуулах хандлага ажиглагдаж байна. Энэхүү судалгаагаар хүн амын гадаадаас буцах шилжих хөдөлгөөний нийгэм эдийн засгийн нөлөөг харуулж, мөн үүнд нөлөөлж буй хүчин зүйлсийг тодорхойлж, түүнчлэн шилжин ирэгсдэд тулгамдаж буй асуудлуудыг судлах зорилго дэвшүүлсэн болно. Судалгааны үр дүнд боловсрол, суралцах зорилготой эсэх, гэр бүлийн байдал, хөдөлмөр эрхлэлт гэх үзүүлэлт нөлөөлж байгааг тодорхойлсон.

Түлхүүр үгс: Буцах шилжилт хөдөлгөөн, хөдөлмөр эрхлэлт, эрх зүйн орчин, нөлөөлөгч хүчин зүйлс

УДИРТГАЛ

1. Үндэслэл

Гадаад шилжих хөдөлгөөн нь улс орны эдийн засагт эерэг болон сөрөг үр нөлөөг авч ирдэг. Монголын хувьд эдийн засгийн хүн амын цох үедээрээ явж буй улс юм. Энэ үед гадагш шилжих хөдөлгөөн ихэссэнээр боловсролтой иргэдээ гадагш алдах, хүн амын тоон өсөлтөнд сөргөөр нөлөөлдөг.¹ Иймд хүн амын гадаад шилжилт хөдөлгөөний эерэг дам нөлөөг зайлшгүй анхаарах шаардлагатай. Хүн амын гадаад шилжилт нь гадагшлах болон буцан ирэх гэсэн хоёр урсгалтай байна. Одоогийн байдлаар бидний анхаарал хандуулах шаардлагатай талбар нь хүн амын буцан ирэх хөдөлгөөн юм.

Монгол улсын гадаад бодлогодоо “иргэд гадаадад зорчсон иргэд эх орондоо эргэн ирж, хөгжил дэвшилд хувь нэмрээ оруулахыг дэмжсэн бодлого хэрэгжүүлэхэд түлхэц үзүүлэх”-ээр тусгасан байдаг.² Мөн Алсын хараа 2050-д “хүний эрхийг бүрэн хангасан улс болох”³, “үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлт, хэрэгжилтэд хамаарал бүхий талуудын оролцоог хангасан зохистой тогтолцоог бүрдүүлэх”⁴, “хүн амын тогтвортой хөгжлийг дэмжих”⁵ зорилгуудыг тусгажээ. Тус зорилгуудада хүрэхийн тулд “2041-2050 хооронд ур чадвартай хүний нөөц бүрдүүлэх”⁶, “2021-2030 хооронд

¹ Монгол улс лахь гадаад шилжих хөдөлгөөний өнөөгийн хандлага, төлөв байдал, Б.Мөнхжаргал, Монголын хүн амын сэтгүүл, 2021 Дугаар 31 давхар ишлэв (Worldbank, 2019;)

² Монгол улсын гадаад бодлогын үзэл баримтлал, 2011

³ Алсын хараа 2050, Зорилго 5

⁴ Алсын хараа 2050, Зорилт 5.5

⁵ Алсын хараа-2050” монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа, Зорилго 2.3

⁶ Зорилго 4.5, III үе шат

хүний эрхийг хангахад чиглэсэн олон талт түншлэлийг хөгжүүлэх”⁷, “2041-2050 онд Хүн бүрийн эрх, эрх чөлөөг баталгаатай эдлүүлэх хүний эрхийн түгээмэл соёл төлөвшүүлэх”⁸ зэрэг зорилтууд үйл ажиллагааг төлөвлөжээ. Хүний эрхийн түгээмэл тунхаглалд зааснаар хүн бүр шилжих хөдөлгөөнд хамрагдах эрхтэй. Энэ эрхийг бүрэн эдлүүлэх нь Монгол улсын алсын зорилгод хамааралтай байна. Мөн Алсын хараа 2050 монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаанд тусгаснаар “Гадаадад сурч, хөдөлмөрлөж байгаа монгол иргэдийн мэдээллийн сан бүрдүүлж, тэднийг иргэний эрхээ эдлэх боломж, нөхцөл бүрдүүлэх үйл ажиллагааг төлөвлөсөн байна.

Түүнчлэн монгол улс нь Олон улсын шилжилт хөдөлгөөний байгууллагад нэгдэн орсноороо Шилжигч ажилчид, түүний гэр бүлийн эрхийг хамгаалах тухай конвенцоор дараах үүргийг хүлээсэн байна:

1. Буцан шилжихтэй холбоотой эд хөрөнгө татвар хөнгөлөлтийн эрх зүйн орчин бүрдүүлэх⁹
2. Шилжигч ажилчдад бүхий л талаар зохистой үйлчилгээ үзүүлж, мэдээллээр хангах, интерацитай холбогдуулан шаардлагатай бодлого, хамтын ажиллагааг хөгжүүлэх.¹⁰

Монгол улс шилжин ирэгсдийг дэмжих бодлого баримтлахаар тусгасан ч буцах шилжих хөдөлгөөнд буй тулгамдсан асуудлыг энэхүү бодлого, зохицуулалтаар шийдвэрлэхэд хангалтгүй байна. Иймд Монгол улс олон улсын өмнө хүлээсэн үүрэг, улс орны алсын хараад тусгасан зорилгуудыг гүйцэлдүүлэхийн тулд Монгол улс тоо шинжилгээ, зорилтот судалгаанд суурилсан зохистой бодлого хэрэгжүүлэх шаардлагатай.

Үүний тулд Гадаадаас шилжин ирэгсдэд нөлөөлж буй хүчин зүйлийг тодорхойлсноор гадаадад байгаа шилжин ирэх хүсэлтэй ч энэ хүслээ биелүүлэх боломжгүй байгаа иргэдийн хувьд ямар хүчин зүйлс нөлөөлж байгааг судлах шаардлагатай. Иймд эдгээр хүчин зүйлсийг эконометриксийн аргааг тодорхойлохыг зорилоо.

2. Судлагдсан байдал

Гадаад шилжилт хөдөлгөөний нэг хэсэг болох буцах шилжилт хөдөлгөөнтэй холбоотойгоор монгол улсын хувьд гадаад шилжих хөдөлгөөний хүрээнд:

№	Нэр, Зохиогч, Огноо	Агуулга
